

Та саналаа uranbileg.m@immigration.gov.mn хаягаар өгнө үү.

ТАНИЛЦУУЛГА

“Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн талаар

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-аар Монгол Улсаас гадаадын иргэнийг албадан гаргах, тус улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч болон холбогдох төрийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохицуулдаг.

Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журамд дараах зохицуулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах саналтай байна:

1. Гадаадын иргэнийг албадан гаргах нөхцөл бүрдсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаан/ гэр бүлийн нөхцөл байдал, ар гэрийн гачигдал, хууль хяналтын байгууллагад шалгагдах, эрүүл мэндийн шалтгаан гэх зэрэг/-ыг харгалзан албадан гаргах аас чөлөөлөх нөхцөл практикт үүсдэг бөгөөд энэ нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид тусгагдаагүй байсныг нэмж тусгах;

2. Гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлэх явцад хууль хяналтын байгууллагаас тухайн иргэнийг эрүүгийн болон иргэний журмаар шалгах, эсхүл зөрчил гаргасан гадаадын иргэн албадан гаргасан шийдвэртэй холбогдуулан гомдол гаргах тохиолдолд уг шийдвэрийн хэрэгжилтийг түр түдгэлзүүлж, асуудлыг эцэслэн шийдвэрлэсний дараа албадан гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах зохицуулалтыг нэмж тусгах;

3. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу гадаадын иргэний хяналтын улсын байцаагч нь албадан гаргасан шийдвэрийг цуцлах санал гаргах эрхтэй боловч түүнийг шийдвэрлэх субъектыг зааж өгөөгүй байсныг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга цуцлах тухай шийдвэр гаргах эрх зүйн зохицуулалтыг нэмж тусгах.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оныдугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1 дүгээр зүйл. Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-д дор дурдсан агуулга бүхий дараахь заалт нэмсүгэй:

1/ Хоёрдугаар зүйлийн 2.7 дахь хэсэг:

“2.7.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1.2, 37.1.3, 37.1.12-д заасан зөрчил гаргасан гадаадын иргэний хүсэлт, хүндэтгэн үзэх шалтгаан, хяналтын улсын байцаагчийн үндэслэл бүхий дүгнэлтийг үндэслэн Монгол Улсаас албадан гаргахаас чөлөөлөх эсэх асуудлыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга шийдвэрлэнэ.”

2/ Хоёрдугаар зүйлийн 2.8 дахь хэсэг:

“2.8.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41.7.4-д зааснаар гадаадын иргэний хяналтын улсын байцаагч нь гадаадын иргэнийг албадан гаргасан шийдвэрийг цуцлах тухай үндэслэл бүхий санал гарган гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргад танилцуулна.”

3/ Хоёрдугаар зүйлийн 2.9 дэх хэсэг:

“2.9.Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь энэ журмын 2.8-д заасан саналыг үндэслэн гадаадын иргэнийг албадан гаргасан шийдвэрийг цуцлах тухай шийдвэр гаргана. Цуцлах шийдвэр гарсан өдрөөс тухайн иргэний Монгол Улсад нэвтрэх эрх нь сэргэнэ.”

4/ Хоёрдугаар зүйлийн 2.10 дахь хэсэг:

“2.10.Гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлэх явцад холбогдох хууль хяналтын байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн,

тохиолдолд уг асуудлыг шийдвэрлэх хүртэл хугацаагаар албадан гаргах шийдвэрийг түр түдгэлзүүлж болно. Энэ талаар гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн санд тэмдэглэл хийнэ.”

5/ Хоёрдугаар зүйлийн 2.11 дэх хэсэг:

“2.11.Зөрчил гаргасан гадаадын иргэн албадан гаргасан шийдвэртэй холбогдуулан гомдол гаргасан нь албадан гаргах шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.”

6/ Гуравдугаар зүйлийн 3.14 дэх хэсэг:

“3.14.Ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон гадаадын иргэнийг 3 жилийн хугацаанд Монгол Улсад дахин оруулахгүй.”

2 дугаар зүйл. Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “Гадаадын иргэн, харьяалалгүй хүн (цаашид “гадаадын иргэн” гэх)-ийг Монгол Улсаас албадан гаргах болон албадан гаргах, албадан гаргасан шийдвэрийг гэсний дараа “түдгэлзүүлэх” гэж, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Энэ журмын 3.2.3, 3.4-3.7” гэсний дараа “3.14” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 2 дугаар зүйлийн нэр “Албадан гаргах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэх” гэснийг “Албадан гаргах ажиллагаа” гэж, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “...хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт, танилцуулгыг бэлтгэн...” гэснийг “үндэслэл бүхий дүгнэлт үйлдэн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.5 дахь хэсгийн “тухайн гадаадын иргэний хувийн хэрэг болон” гэснийг, 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсгийн “Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 11.3-т заасан үндэслэл бий болсон буюу” гэснийг, 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсгийн “ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-оргил нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Ж.ЭРДЭНЭБАТ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

С.БЯМБАЦОГТ